

2.15. ХҮНИЙ АМЬДРАЛЫН УТГА УЧРЫН ТАЛААРХ ЭКЗИСТЕНЦИАЛИСТ БАРИМТЛАЛЫН ОНЦЛОГ

Товч утга. Хүн төрөлхтний өмнө байнга тулгарч ирсэн асуудлуудын нэг бол хүний оршихуйн зорилго, утга учрын тухай асуудал мөн. Энэ нь өөрөө хүний уг чанарыг тодорхойлох нэг чухал хүчин зүйл болдог билээ.

Эртнээс эдүгээ хүртэл хүнийг шинжлэн судлах, ертөнцийг шинжлэн судлах нь хүн төрөлхтний тайлж мэдэх мөнхийн голлох хоёр сэдэв байсан боловч бид сүүлчийнх рүү нь илүү анхаарлаа хандуулсан бөгөөд өнөөдөр хүний оршихуйн асуудал хамгийн нууцлаг, ээдрээтэй асуудал хэвээр байна.

Орчин үед философийн антропологи хэмээх бие даасан чиглэл хөгжих болов. Энэ нь эдүгээ философид хүний асуудал онцгой байр суурь эзлэх болсоныг харуулж байна.

Философийн түүхэн дэх сонгодог үеийн ихэнх философичид ахуйн ухаан, мэдлэгийн хүчин зүйлс хүн төрөлхтний амьдралыг хувирган өөрчлөх гол хэрэгсэл болно гэдэгт бүрэн итгэлтэй байсан. Харин XIX зууны үеэс философичид хүний тухай асуудлыг илүү нарийвчлан судлах болсон ба тухайлбал, хүний оршихуйн утга учир, үүрэг зорилгын тухай үзэл орчин үеийн Өрнөдийн философи тэр тусмаа экзистенциалист философид гол судлах зүйл нь болсон билээ.

Хүний амьдралын утга учрын тухай асуудал нь ёс суртахууны философийн нэгэн чухал сэдэв мөн. Тиймээс ч эл асуудлаар гадаад, дотоодын эрдэмтэд, судлаачид олон бүтээл туурвиж, нийтийн хүртээл болгожээ. Манай орны хувьд сүүлийн жилүүдэд хүн ба нийгмийн харилцан хамаарал, хүний амьдралын утга учир, хүн байхын утга учрын холбогдолтой судалгааны бүтээлүүд цөөнгүй гарч, тэдгээрт судлаачид өөрсдийн санаа бодол, үндэслэгээг дэвшүүлжээ. Тухайлбал, доктор Д.Дагвадорж, доктор Ц.Балхаажав, доктор Б.Батчулуун, доктор Р.Дарьхүү, доктор Д.Тунгалаг, доктор Б.Дагзмаа, доктор А.Цэрэннадмид, доктор Ц.Баатартогтох нарын олон судлаачдын бүтээлийг¹ нэрлэж болно.

Түлхүүр үг. Амьдралын утга учир, эзэрхэх хүсэл зориг, *dasein*, амьдралын утга учиргүйдэл, тэрсэлдээн гэх мэт

XIX зууны эхний хагаст Гегелийн философи оргилдоо хүрсэн сонгодог рационалист философитой зэрэгцээд танин мэдэхүйн дээд ололт бол гагцхүү шинжлэх ухаан, оюун ухааны ач тус гэсэн үзлийг эсэргүүцэн шүүмжилдэг олон тооны философийн үзэл сургаал бий болсон билээ.

¹ Д.Дагвадорж. Хүний тухай шарын шашны үзэл-онол, ёс суртахууны үндэс. УБ.,2002. Ц.Балхаажав. Хүн та хэн бэ? УБ.,2001. Б.Батчулуун. Хүний философийн асуудал. УБ.,2001. Р.Дарьхүү. Өрнө дорнын философи дахь хүний тухай асуудал. Дис. УБ.,1996. Д.Тунгалаг. Гэр бүлийн ёс зүй. УБ., 2000. Б.Дагзмаа. Проблема смысла человеческого существования в философии И.Канта и экзистенциализма. Дис.УБ.,2000. А. Цэрэннадмид. Хүн ёс хүн төрх зан суртахуун. УБ.,2001

Мэдлэгийн тухай нийтлэг үзэл баримтлалыг нь онцлох үндсэн дээр тэдгээр үзэл сургаалд иррационалист гэсэн ерөнхий тодотгол нэр өгдөг юм. Рационалист философи ихэвчлэн байгалийн шинжлэх ухааны ололт амжилтан дээр тулгуурлан асуудлыг тайлбарлан шийдвэрлэдэг гэж хэлж болно. Харин иррационалист философи хүний асуудал руу гол анхаарлаа хандуулдаг гэж хэлж болох талтай. Тийм ч учраас сонгодог бус философийн түүхэнд хүний орших аргыг нөхцөлдүүлэгч олон тооны өөрийн гэсэн өвөрмөц онцлог, статус бүхий философи урсгал чиглэлүүд үүссэн болов уу?

Тэдгээр философичдын авч үзэх гол асуудал бол гүн хямралд байгаа нийгэм дэх хүний амьдралын утга учир болоод ертөнцийг үзэх үзлийн асуудал байсан юм. Өөрөөр хэлбэл, тэднийхээр хүний сэтгэл санаа гаж мэдрэмжтэй болж, тэр нь улам бүр өргөжин байгаа бөгөөд үүнийг даван туулахад нь туслахгүй бол хүн өөрийн амьдралын утга учрыг хамгийн эмгэнэлтэй, утгагүй байдалд олж харах ажээ.

Ийнхүү экзистенциалист философийн томоохон төлөөлөгчид нийгмийн харгис улс төрийн дэглэм, хүчирхийллийг эрс шүүмжилж, орчин үеийн хүний цөхөрсөн эмгэнэлт дүрийг өөрсдийн зохиол бүтээлдээ тусгасан байдаг. Тухайлбал: Ж.П.Сартрын "Огюдас", "Оршуулагагүй үхэгсэд" болон А.Камюгийн "Босуул", "Тахал", "Гадны хүн", "Сизифийн домог" зэрэг бүтээлүүдийг нэрлэж болно.

Экзистенциалист философийн анхны үндэс суурийг тавьсан хүн бол Данийн философич С.Кьеркегор бөгөөд хожим энэ философи нь түүний боловсруулсан философийн гол гол ойлголт категориудыг уламжлан авч хэрэглэсэн юм. Тэрээр хүний амьдралын мөн чанарын асуудлыг гутранги үзэл санааны өвөрмөц ойлголтуудыг анх хэрэглэж тайлбарласан нь бусад философи үзэл баримтлалуудаас эрс өөр төдийгүй, хожим судлаачдын анхаарлыг ихэд татсан гэдэг.

Мөн амьдралын философийн томоохон төлөөлөгч Германы философич Ф.Ницше (1844-1900)-ийн үзэл баримтлал XX зууны экзистенциалист философид хүчтэй нөлөө үзүүлсэн.

Ф.Ницшегийн философи дахь эзэрхэх хүсэл зориг нь амьдрах хүч тэмүүлэл, байгалиас заяасан энерги мөн бөгөөд энэ нь амьдралын үндсэн шинж, мөн чанар юм. Өөрөөр хэлбэл, эзэрхэх хүсэл зориг хэмээх ойлголт нь амьдралын бүтээлч мөн чанарыг илэрхийлсэн ойлголт гэж үзэж болно. Энэ талаар Ф.Ницше бичихдээ "Ямар нэгэн юм байнга хүчээ илэрхийлж байхыг хүсдэг ба энэ нь амьдрал өөрөө эзэрхэх

хүсэл зориг мөн”¹ гэжээ. Амьдралын мөн чанарыг илэрхийлсэн энэхүү ойлголт нь амьд организм үүсч, хөгжиж, мөхөх тухай үзэл санаа төдийгүй амьдралын гол шинж бол өөрийгөө хамгаалах явдал бус, харин үргэлж өсөж өндийх явдал гэдгийг онцолдог.

Мөн Ф.Ницшегийн философид яригддаг бас нэг ойлголт бол үнэт зүйлсийн тухай ойлголт байдаг. Энэ нь амьдралын утга учрын асуудалтай нягт холбоотой байдаг явдал юм. Хүн ямар нэг зүйлийг үнэлж, түүнд тэмүүлэх нь тухайн хүний хувьд амьдралынх нь утга учир болж байдаг тухай өгүүлсэн нь объектив үндэслэлтэй санаа юм.

Экзистенциализмд олон чухал категорийг боловсруулж, түүнийг үндэслэгчдийн нэг гэж тооцогддог хүн бол Германы философич М. Хайдеггер (1889-1976) билээ. Түүний философийн үндсэн зорилго бол орчин үеийн гүн хямралт нийгэмд хүн хэрхэн амьдрах, ямар хувь заяа эдлэх ёстойг ухааруулах явдал ажээ. Учир нь хүний амьдралын дүр зураг М.Хайдеггерынхаар нэлээд гунигтай байдлаар дүрслэгдсэн байдаг. Түүний гол бүтээл нь “Ахуй ба цаг хугацаа” гэдэг зохиол бөгөөд энэхүү зохиолдоо экзистенциалист үзэл санаагаа боловсруулсан буй.

М. Хайдеггер философийн авч үзэх ёстой үндсэн асуудал бол матери, ухамсрын харилцааны асуудал биш, харин хүний ахуй, амьдралын утга учрын асуудал байна гээд үүний үндэс нь ахуйн утга учраас эхлэх ёстой ажээ. Тэрээр ахуйн уг чанарыг нээх нь философийн гол асуудал болдог гээд “Dasein” хэмээх ойлголтыг хэрэглэсэн байна. “Dasein” буюу хүний ахуй нь ахуйн талын гол зангилаа асуудал бөгөөд энэ бол хүн төрөлхтний оршихуйн үндсийг агуулдаг жинхэнэ ахуй юм. Ер нь М. Хайдеггерын хэрэглэсэн ахуй бол ухамсрын ахуй юм.

Түүний зэрэгцээ М. Хайдеггер амьдрал ямагт үхэл өөд тэмүүлж байдаг гээд, хүн энэ байдлаа ухаарч чадах юм бол өөрийн амьдралын төгсгөлт чанар мөн үүрэг хариуцлага, эрх чөлөө, жинхэнэ чанараа ухаарах боломжоо олдог. Ингэснээрээ хүн үхлээс өрсөн амьдралаа утга төгөлдөр болгож чадах ажээ. Экзистенциалист философичид хүний ирээдүй нэгэнт харанхуй, үхэх л тавилан хүлээж буй учир энэ байдлаа түр мартаад, харин амьдралынхаа алхам тутамд аз жаргалыг мэдэрч өнгөрөөхийг чухалчилдаг санаа М. Хайдеггерын философид тод илэрдэг.

Экзистенциалист философичид дотроос Францын философич Альбэрт Камю (Albert Camus) шашингүйн экзистенциализмын томоохон төлөөлөгч бөгөөд тэрээр

¹ Ф.Ницше. По ту сторону добра и зла. - Ф.Ницше. соч., в 2-х томах. Т., 1. М., 1990. с.250

хүний оршихуй, амьдралын утга учрын асуудлаас утга учиргүйдлийн (абсурд) тухай асуудлыг илүүтэйгээр гарган тавьсан онцлогтой.

А.Камю өөрийн үзлийг зөвхөн гүн ухааны зохиол бүтээлүүдээр төдийгүй, мөн утга зохиолын төрлүүдээр (роман, тууж, жүжгийн зохиолууд гм) илтгэдэг ба бичлэгийн хэв маяг нь уран дүрслэл, зүйрлэл ихтэй эссэ (essay) байдаг. Тэрээр зохиолдоо тухайн нэг хувь хүний амьдралыг төдийгүй, тухайн хүнээс нийгэмтэй болон байгаль ертөнцтэй хандах хандлага зэргийг нарийн тусган илэрхийлсэн байдаг.

А.Камюгийн хувьд бурхан тэнгэрт итгэх итгэл нь алдагдсан, мөн хүний оршихуйн туйлын утгаараа төгсгөлөг, өөрөөр хэлбэл, хүн тус бүрийг төгс устал, үнэхээр юу ч биш хүлээж байгаа гэдэг утгаар түүний үзэл санаа өрнөдөг. Тийм учраас А. Камю "Тэнгэр бурханд итгэх хүний итгэлд үлдэх орон зай байхгүй болсон учраас хүний оршихуй юу ч биш болсон гэдгийг хүлээн зөвшөөрөх цаг иржээ. Энэ нь хүний амьдралд бодитой, тодорхой утга учир болгох үндэслэл байхгүй гэсэнтэй утга ижил юм"¹ гэсэн шашингүйн үзлийг баримталсан байна.

А.Камю хүний амьдрал утга учиргүйдлээр дүүрэн гээд, хүний оршихуйн утгагүй байдлыг задлан шинжлэхдээ өөрийн анхны бүтээлүүдийн нэг болох "Гадны хүн" туужийнхаа гол баатрын амьдралаар дүрслэн үзүүлсэн байдаг. Энэ туужид гол баатар болох Мерсо өөрийнхөө амьдралын тухай ярьдаг. Түүний амьдрал нь нэгэн хэвийн уйтгарт байдалд байх ба Мерсод ямар ч онцгой сонирхол, сэтгэл нь татагддаг зүйл гэж үгүй. Түүний эх нь өндөр настны асрамжийн газарт амьдардаг. Тэр ээжийгээ хааяа л эргэдэг. Удалгүй ээж нь нас барж, оршуулах ёслолын үйл ажиллагааг тэгэс ингэсхийн өнгөрөөдөг. Мөн түүнд нэг эмэгтэй байдаг ба тэдний хооронд ямар нэгэн тааламжит харилцаа үгүй, тэд санаа бодлын хувьд огт өөр хүмүүс. Мерсо юунд ч тэмүүлдэггүй, юуг ч хүсдэггүй нэгэн. Хэдийгээр тэр нийгмийн дотор, хүмүүсийн дунд амьдарч буй боловч тэр бүхэн түүнд огт хамаагүй мэт, хүрээлэн буй бүхнээс ангид яг л гадны хүн мэт амьдардаг.

Гэвч түүнд ганц л хайрлах зүйл байдаг. Энэ нь байгаль. Мерсо бол байгальд дурласан хүн. Далай, агаар, нар, устай харьцахад энэ л түүнд цорын ганц жаргал авч ирдэг. Ингэж л Камюгийн зохиолын баатар амьдардаг. Гэвч энэхүү нэгэн хэвийн, нэг янзын амьдрал нь нэг л өдөр алдагдахад хүрнэ. Тэрээр нэгэн удаа далай руу зугаалж явахдаа яагаад ч юм буу авч явна. Дараа нь тэр яах гэж ингэснийгээ тайлбарлаж чаддаггүй. Нэгэнт буу авч явсан нь тэр наад зах нь бай буудах, цаашлаад ан хийх

¹ Эрх чөлөө ба философи. УБ., 2000. 4 дэхь тал.

сонирхолтой байсан байх. Гэтэл Мерсо далай эрэг дээр байсан нэгэн Араб эрийг буудан алдаг. Шүүх хурлын үед түүний үйлдсэн гэмт хэргийн фактаас гадна, Мерсогийн хувь хүний онцлог араншин тэнд байгаа бүх оролцогчдыг маш их зэвүүцүүлдэг. Яагаад гэвэл Мерсо амьдралд хандах хандлага, түүнийг үнэлэх үнэлэмж зэргээрээ тэд нараас эрс өөр байлаа. Түүнийг шүүх хуралд оролцогчид нийгэмд тогтсон ёс заншлыг үл хүндэтгэгч дайсан мэтээр хүлээн авдаг. Улмаар түүнд цаазаар авах ял төлөвлөж, ялын тогтоолыг уншихад тэр юу ч болоогүй мэт сонсон сууна. Цаазлагдах ялтнуудын камерт Мерсо дээр лам ирээд түүнийг өөрийн хийсэн хэрэгтээ гэмшиж байна уу? гэхэд “Миний зөв байсан, одоо ч миний зөв, миний зөв байх болно. ... Бусдын үхэл, бурхан, сонгож болдог амьдралын замууд, эрхэмлэн хүндэтгэдэг зүйлс энэ бүхэн надад ямар хэрэгтэй юм бэ? Тэртэй тэргүй бүх хүнд цорын ганц тавилан, үхэх тавилан л ноогдсон” гэж хариулдаг.

Камю энэ туужийнхаа талаар “Нэгэнт бид үхэх юм бол амьдрал болон бусад бүх юм утга учиргүй. Энэ бол Мерсогийн гүн ухааны үзэл мөн” хэмээн тайлбарласан байдаг. Энд нэг зүйлийг тайлбарлахад Мерсогийн үзлийг дан ганц Камюгийн үзэл гэж авч үзэж болохгүй. Мөн Мерсогийн үзэл санаа, амьдралд хандах хандлагыг Камюд ямар ч хамаагүй гэж хэлж болохгүй. Энэ бол түүний философи санаануудын нэг чиглэл юм. “Гадны хүн” зохиолын гол баатар болох Мерсогийн илэрхийлж буй дээрх үзэл санаа нь А.Камюгийн сэтгэлийг зовоодог, түүнийг даван туулахыг хичээдгийг түүний бусад зохиол бүтээлүүдээс харж болно.

Тухайлбал тэрээр “Сизифийн домог”¹ зохиолдоо Сизифийн дүрээр хүний амьдралын утга учрын асуудлыг нарийвчлан шинжилсэн байна. Сизиф бол эртний Грекийн домгийн баатар мөн. Тэнгэр бурхан түүнийг өөрийнх нь эсрэг тэрсэлсэнийх нь төлөө түүнд уулын оройд дааж гаргахгүй хүнд чулууг гаргах шийтгэл оноодог. Энэхүү шийтгэл хэзээ ч бүтэшгүй гэдгийг Сизиф мэдэж байсан боловч зүтгэсээр байгаа нь тэрээр тэнгэр бурхантай эвлэршгүй байгаагийн илрэл болдог. Энэ домгийн агуулгаас Камю дүгнэлт хийхдээ: Сизиф бол утга учиргүйн баатар мөн. Дааж давашгүй, хэлж баршгүй зовлон оноосон. Газрын хүн болж төрсөний ач “гавъяа” ердөө л энэ хэмээн бичжээ. Түүнчлэн А.Камю нь “Хүн оюун ухаанаараа хувь заяагаа ухаарч, амьдралын дарамтыг үүрч, түүнтэй эвлэрэхгүйгээр үр өгөөжтэй, бүрэн дүүрэн тэмцэж амьдрах болсоноор түүний амьдрал утга төгөлдөр болно” хэмээн хүний амьдралын утга учрыг тодорхойлсон буй. Энэ нь түүний гол үзэл санаа мөн.

¹ А.Камю, Миф о Сизифе. Бунтарь. Минск. 1998

Хувь хүний төдийгүй хүн төрөлхтний амьдрал тийнхүү утга учиргүйдэл юм бол бид юунд найдаж, юуны төлөө амьдрах вэ? гэсэн асуудалтай тэрээр тулгарчээ. Түүнийхээр хэрэв хүн утга учиргүйдлийг ойлгосон бол амьдрал өөртөө үнэлэмжтэйг ойлгоод оршихуйгаа хадгалж үлдэхийн тулд тэрсэлдэх замыг сонгодог гээд А.Камю өөрийн "Тэрслэгч" бүтээлдээ дээрх асуултынхаа хариултыг улам тодотгожээ. Тухайлбал: хүнд зөвхөн байгаль ертөнц төдийгүй нийгэм, нийгмийн харилцаа харь ондоо байдаг гээд ийм харь нийгэмд яаж зохицож амьдрах талаар бичжээ. "Хүний амьдралын утга учиргүйгээс гарах гол арга зам бол түүний эрх чөлөө, тэрсэлдээн юм"¹ гээд ерөөс "эрх чөлөө" гэдэг асуудал утгагүй хэмээн үздэг. А.Камю "Тэрслэгч" бүтээлдээ тэрсэлдээн гэж юу болох, хэн тэрслэгч байх, ямар зорилготой юуны төлөө тэмцэх вэ? гэдэгт тодорхой хариу өгсөн байдаг. Тэрслэгч гэж хэн бэ гээд энэ бол "үгүй" гэж хэлж чаддаг хүн. Энэ нь утга учиргүй, эмх цэгцгүй байдлын эсрэг тэмцэгч байх явдал бөгөөд хүний төрөлх шинж байна гэдгийг онцлон үзсэний илэрхийлэл ажээ. Тэрсэлдээн нь хүний ухамсартай холбоотой болохыг "Тэрсэлдээн бол эрхээ бат ухамсарласан хүний явдал" гэж тэрээр тодорхойлжээ. Хүн төрөлхтөн эв нэгдэл, оюун ухааныхаа ачаар л түүхийнхээ явцад өөрийгөө бүрэн дүүрэн, гүн гүнзгий ухааран ойлгодог. Хүн ертөнц нь адгуусны ертөнцөөс нэг л зүйлээрээ ялгагдаж байх ёстой, тэр нь энэрэнгүй, хүнлэг байх чанар бөлгөө.

Эцсийн эцэст хүний амьдрал өөрөө хамгийн дээд үнэлэмжийн зүйл бөгөөд үүнийг хадгалж, нэр төртэй цааш авч явах нь хүний амьдралын утга учир байх ёстой гэсэн санаанд үндэслэж дүгнэлт хийсэн байдаг.

Тийм учраас "философийн үндсэн асуудал бол матери ухамсрын харилцааны төдий асуудал бус, харин философийн судлах зүйл бол хүн, хүний оршин ахуй, амьдралын утга учрын асуудал мөн" хэмээн тэрээр үзжээ. Цааш нь "философийн хос категориуд байдаг эсэх, ертөнц 3 хэмжээстэй эсэх зэрэг нь бүгд хоёрдугаар зэргийн асуудал. ... Галилей өөрийгөө шинжлэх ухааны үнэнд зориулсан. Гэтэл энэ нь түүнд эргээд аюул авчирсан. Дэлхий нарыг тойрч байна уу, нар нь дэлхийгээ тойрч байна уу ямар ч хамаагүй биш үү? Ер нь эдгээр асуултууд бол хий дэмий хоосон зүйл гээд, харин амьдралын утга учрын асуудал л хойш тавимгүй чухал асуудал"² гэж үзжээ.

¹ Р. Дарьхүү. Дорнын болон өрнийн философи дахь хүний асуудал. УБ., 1996. 45 дахь тал

² К.Ю. Мельвил, А.Ф. Зотов. Западная философия XX века. М., 1998. стр.,96

Мөн тэрээр цааш үргэлжлүүлэхдээ: "Хэрвээ надаас ямар үндсэн дээр чи үүнийг хамгийн чухал асуулт гээд батлан хэлээд байгаа юм бэ гэж асуувал, энэ чинь угаасаа хүний хийж буй үйлдлүүдээс тодорхой байна шүү дээ гэж хариулна"¹ гэжээ.

Ямар нэг байдлаар яаж ийж тайлбарлагдаж буй ертөнц бол бидний танил, дассан ертөнц юм. Гэвч орчлон ертөнц гэв гэнэт хуурмаг үзэгдэл болон учир нь ойлгогдохоо боливол хүн өөрийгөө шууд л гадны хөндлөнгийн юм шиг ойлгоно. Энэ байдал хүнд цөллөг мэт санагдаж, өөрийн итгэл найдвараа алдсан мэт мэдрэмж түүнд төрж, амьдрах хүсэл төрөхөө болино. Ингэж А. Камюгийн философийн чухал ойлголт гарч ирдэг. Энэ бол утга учиргүйн тухай ойлголт. Ийм болохоор А. Камюгийн философийг заримдаа "утга учиргүйн философи" ч гэж нэрлэх тохиолдол байдаг.

Түүнчлэн А. Камю хүний оршихуйн утга учиргүйдэл бол өөрийнх нь оршихуйн шинжээр тодорхойлогддог гэсэн санааг үндэслэсэн. Үүнд, хүн жинхэнэ оршихуй, оршихуйнх нь агуулгыг хоорондын холбоо ойлгогдохгүй байдаг төдийгүй хүн цаг ямагт өөрөө өөртөө ч харь хэвээрээ байдаг нь түүний оршихуйн утга учиргүйдлийн бас нэг илрэл юм.

А.Камюгийн үзлээр "Хүний мөн чанар бол өөрийн ухамсар болно". Утга учиргүй хүний хорвоо бол гал усны хорвоо бөгөөд хичнээн хязгаарлагдмал болох тусам төдий чинээ яруу тунгалаг бүх юм өгөгдсөн атлаа боломжтой юм юу ч үгүй хорвоо юм. Иймээс хүн өөрийгөө таньж өөрийн хүчээ олж, тайвшралгүйгээр шаргуу зүтгэх хэрэгтэй гэж хүний өөрийн хүчинд итгэж, идэвхтэй амьдрахыг чухалчилсан юм.

А.Камюгийн амьдарч асан нийгэм аллага, амиа хорлолт гэх мэт сөрөг үзэгдлээр арвин байсан учраас үүнд анхаарлаа хандуулах нь зайлшгүй байсан байх аа.

Эцэст нь дүгнэн хэлэхэд экзистенциалист философид хүний дотоод амьдрал буюу сэтгэл санааны амьдралын тухай асуудлыг голлон авч үздэгээрээ бусдаас онцлогтой. Экзистенциализмын үзлээр, аливаа хүн эгзэгтэй мөчид, тухайлбал, үхлээс айх, амьдрал утга учраа алдсан үед сэтгэл хөдлөлийн хурц үед экзистенци илэрдэг. Ийм үед хүн энэ ертөнцийн эрхшээлээс ангижирч, жинхэнэ амьдралтайгаа учирдаг. Ингэж жинхэнэ амьдралаа бүтээдэг. Өөрөөр хэлбэл, амьдралд өөрийнхөөрөө хандаж эхэлдэг. Иймд экзистенци нь хүний амьдралыг урамшуулагч, идэвхтэй хүчин юм. Түүнчлэн хүний амьдралыг тодорхойлогч гол зүйлүүд нь эрх чөлөө, сонголт,

¹ К.Ю. Мельвил, А.Ф. Зотов. Западная философия XX века. М., 1998. стр.,99

хариуцлага, өөрийн ухамсар хэмээн экзистенциализмд үздэг. Хүн эрх чөлөөтэй байхын хирээр хариуцлагатай байх учиртай.

Мөн үхлийн тухай мэдлэг нь амьдралыг чиглүүлэхэд нөлөөлөх, өөрчлөх хүч болох тухай, хүн өөрийн амьдралын зорилгыг ирээдүйтэй холбон үл хойшлуулах, үл тайвшрахыг экзистенциализмд анхааруулсан буй.

Бид амьдралынхаа утга учрыг хором бүрд ухаарч амьдрах нь хамгийн чухал ажээ. Тэгэхлээр хүний дотоод ухамсар, сэтгэл, хүсэл эрмэлзлэл нь хүний амьдралыг тодорхойлох голлох хүчин зүйлүүд болно. Өөрийн эрх чөлөөг мэдрэхийн зэрэгцээ үүрэг хариуцлагаа ч дээшлүүлэх нь өнөөгийн бидэнд тун чухал ач холбогдолтой. Энэ бүхнээс бидний амьдралын утга учир ч нэлээд хамааралтай болох нь тодорхой байна.

Өнөө үед манай орны хувьд хүмүүс өөрсдийн амьдралын утга учрыг тунгаан бодож олох асуудал чухал юм. Нийгмийг ардчилах үйл явцад ч хүмүүст өөрсдийн амьдралыг чөлөөтэй бөгөөд бие даасан байдлын үндсэн дээр ойлгох ухамсар, хариуцлага сул байгаа болно. Иймд өнөөгийн бэрхшээлтэй үед амьдрал, үүний утга учир өөрөөс шалтгаална гэдгийг, мөн хөдөлмөрч, бүтээлч байхад оршино гэдгийг хүмүүс ухамсарлах хэрэгтэй болов уу?

НОМ ЗҮЙ

1. Анатология мировой философии. М., 1971
2. Губин. В, Некрасова.Е. Философская антропология. М., 2000
3. Камю.А. Миф о Сизифе. Бунтарь. Минск., 1998
4. Канке. В.А. Философия. Киев. 2000
5. Мельвил.Ю.К. Зотов.А.В. Западная философия XX века. М., 1998
6. Ц.Балхаажав. Хүн та хэн бэ?. УБ., 2001 он
7. Б. Батчулуун. Хүний философийн асуудал. УБ., 2001
8. Р. Дарьхүү. Дорнын болон өрнийн философи дахь хүний асуудал. УБ., 1996
9. Р.Дарьхүү. Хүний уг чанар, мөн чанарын тухай А.Камюгийн үзэл-МУИС. ЭШБ. №5(142). УБ., 1999
10. Эрх чөлөө ба философи- YI .УБ., 2000 он